

Төрийн албаны зөвлөлийн  
2020 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн  
399 дугаар тогтоолын 22 дугаар хавсралт

## АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

### I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон  
Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Туул голын сав газрын захиргаа

Албан тушаалын нэр:

Хяналт, шалгалтын асуудал хариуцсан мэргэжилтэн

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Нэгжийн нэр:

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-5

Ажлын байрны албан ёсны байршил:

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

### II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ

Албан тушаалын зорилго:

Байгаль орчныг хамгаалах тухай, Зөрчлийн тухай хууль, Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Захиргааны ерөнхий хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай болон байгаль орчны багц хууль тогтоомж, дагаж мөрдөх дүрэм, журам, стандартын хэрэгжилтийг хангуулах, ус ашиглалтын байдалд хяналт тавих, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах, хүрээлэн буй орчны эсрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, бууруулах, зөвлөн туслах, дүгнэлт үнэлгээ гаргах, ажлын гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

1.Төрөөс усны талаар баримтлах бодлого, сав газрын менежментийн төлөвлөгөөнд хариуцсан чиг үүргийг хэрэгжүүлэх зорилгоор байгууллагын болон албаны тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгаж, байгаль орчны хяналт шалгалт, үнэлгээтэй холбоотой арга хэмжээг хэрэгжүүлэх, тайлагнах.

2.Иргэн, аж ахуйн нэгж байгууллагын үйл ажиллагаанд Төрийн хяналт шалгалтын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Усны тухай хууль, бусад хууль тогтоомжийн хүрээнд байнгын (төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус) хяналт тавьж, үнэлгээ хийх, мэргэжил аргагүйгээр хангах.

3.Ус ашиглах, хаягдал ус зайлуулах шаардлагыг зөрчсөн иргэн, аж ахуйн нэгж байгууллагын ус ашиглах, хаягдал ус зайлуулах эрхийг цуцлах дүгнэлт гаргах байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах.

4.Албан тушаалын чиг үүргийн дагуу гүйцэтгэх бусад ажил.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах - Т, Хариуцан гүйцэтгэх - Г Хянах – Х Шийдвэрлэх – Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Хариуцсан чиг үүргийн дагуу Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, “Ус” үндэсний хөтөлбөр, сав газрын менежментийн төлөвлөгөөнд тусгагдсан ажлыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах;	Зохих журмын дагуу тайланг хугацаанд нь нэгтгэн гаргаж, үр дүнг танилцуулсан байна.	Г
	2.Байгаль орчныг хамгаалах тухай хууль болон бусад хууль, тогтоомж, холбогдох дүрэм журмын хэрэгжилтийг хангуулах;	Хяналт шалгалтын баримт бичиг, тайлан мэдээг холбогдох хууль тогтоомж, дүрэм, журам, стандартын дагуу үнэн зөв боловсруулж, тогтоосон хугацаанд холбогдох газарт хүргүүлсэн байна.	Г
	3.Сав газрын хэмжээнд байгаль орчны тэнцвэрт байдлыг хадгалах, нөхөн сэргээх, экосистемийн тэнцвэртэй байдлыг хангахад иргэд, олон нийтийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх.	Эрсдэл буурсан байна.	Г
2 дугаар зорилтын хүрээнд	1.Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн дагуу Байгаль орчны хяналтын улсын байцаагчийн эрх, үүргийг хэрэгжүүлж ажиллах;	Сав газарт орон нутгийн хууль хяналтын байгууллагатай хамтран хяналт шалгалтыг зохион байгуулсан байна.	Г
	2.Усны тухай хууль, холбогдох бусад хууль тогтоомж, сав газрын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх чиглэлээр бүх шатны Засаг дарга, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлыг мэргэжлийн зөвлөмжөөр хангах;	Мэргэшил, арга зүйн зөвлөгөө нь хууль зүйн үндэслэлтэй байна.	Г
	3.Хяналт, шалгалтын төлөвлөгөө гаргаж, төлөвлөгөөт болон	Хяналт шалгалтаар илэрсэн зөрчилд	Г



	төлөвлөгөөт бус хяналт шалгалтыг тогтмол явуулж ус ашиглагч, ус бохирдуулагч иргэн, аж ахуйн нэгж байгууллагуудад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, илэрсэн зөрчил дутагдлыг таслан зогсоох, арилгуулах, хариуцлага тооцох ажлыг зохион байгуулах.	холбогдох хууль тогтоомжийн дагуу арга хэмжээ авах, нотлох, баримтжуулах, гүйцэтгэлийг хангуулсан байна.	
3 дугаар зорилтын хүрээнд	1.Сав газарт ашигт малтмалын хайгуул хийх, олборлолт явуулах тусгай зөвшөөрөл олгох;	Мэдээлэл нь нотолгоонд тулгуурласан, үндэслэлтэй байна.	Г
	2.Байгальд учруулсан хохирлыг нөхөн төлүүлэхээр шүүхэд нэхэмжлэл гаргах;	Шүүх, хуулийн байгууллагын шаардсан материал, нотлох баримтыг бүрдүүлэн хүргүүлсэн байна.	Г
	3.Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс дэх эвдэрсэн газрын нөхөн сэргээлтэд хяналт тавих.	Холбогдох судалгааг хийж, хяналт тавьж ажилласан байна.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Төрийн албаны тухай хууль, тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг хангах, албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг хуульд заасан хугацаанд үнэн зөв гаргах, авилга, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;	Хууль тогтоомжийн хэрэгжилт хангагдсан байна.	Г
	2.Төрийн үйлчилгээний ил тод, нээлттэй байдлыг ханган, өдөр тутмын ажлыг мэргэшлийн түвшинд чиглүүлэх, үйл ажиллагаанд хяналт тавих;	Иргэдэд үзүүлэх төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлсэн байна.	Г
	3.Удирдлагын хуульд нийцсэн үүрэг даалгаврыг шуурхай биелүүлэх, эргэн мэдээлэх.	Төрийн албан хаагчдын ёс зүйн зөрчил гаргахгүй ажилласан байна.	Г
<b>III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА</b>			
Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй байх.		
Мэргэжил	<ul style="list-style-type: none"> <li>- гидрогеологи инженер, геологи /053204/;</li> <li>- геофизик /053205/;</li> <li>- ус судлал /052202/;</li> <li>- эрхзүй /042101/;</li> <li>- экологи /052101/;</li> <li>- усны менежмент.</li> <li>- усны нөөц, экологи;</li> <li>- усны барилга байгууламжийн инженер.</li> </ul>		
Мэргэшил	Төрийн албаны богино болон дунд хугацааны сургалтад хамрагдаж төгссөн байх.		
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.		
		- судалгааны арга зүйн мэдлэгтэй, ашиглах чадвартай байх;	



Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	<ul style="list-style-type: none"> <li>- мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх;</li> <li>- гүйцэтгэж буй ажлын явц, үр дүнг тайлагнах;</li> <li>- албан тушаалын чиг үүргээ хэрэгжүүлэхэд учирч болзошгүй эрсдэлийг урьдчилан тооцох, бууруулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх;</li> <li>- байгууллагын дотоод хяналтыг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд оролцох, үр дүнг тайлагнах;</li> <li>- бусад</li> </ul>
	Асуудал шийдвэрлэх	<ul style="list-style-type: none"> <li>- Монгол Улсын Үндсэн хууль, бусад хуулийг чандлан баримталж, үндэсний язгуур ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж, төрд чин үнэнчээр зүтгэх;</li> <li>- албан тушаалын бүрэн эрхийн хүрээнд асуудлыг хууль болон ёс зүйн зарчимд нийцүүлэн ашиг сонирхлоос ангид шийдвэрлэх;</li> <li>- асуудлыг шийдвэрлэх хувилбарыг боловсруулж, түүний эерэг, сөрөг үр дагаврын талаар удирдлагад танилцуулах;</li> <li>- саналын зөрүү, үл ойлголцлыг эв зүйгээр зохицуулах;</li> <li>- бусад</li> </ul>
	Багаар ажиллах	<ul style="list-style-type: none"> <li>- өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж, бусдыг дэмжих, хамтран ажиллах;</li> <li>- бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох;</li> <li>- ажлын цаг ашиглалтын хувьд хамт олныг үлгэрлэх;</li> <li>- багийн зорилго, үйл ажиллагааг ойлгож, дасан зохицож ажиллах;</li> <li>- багийн дунд хүлээсэн үүргээ гүйцэтгэх;</li> <li>- бусад</li> </ul>
	Бусад	<ul style="list-style-type: none"> <li>- албан хэрэг хөтлөх, бодлогын баримт бичиг боловсруулах;</li> <li>- англи хэл, эсхүл бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийг ашиглах;</li> <li>- компьютерын хэрэглээний программ, мэдээллийн технологийн аргыг ашиглах;</li> <li>- бусдад хүндэтгэлтэй, соёлтой, адил тэгш хандах;</li> <li>- кирилл болон үндэсний бичгээр уншиж, бичих чадвартай байх;</li> <li>- жендерийн тэгш байдлыг хангах.</li> </ul>

#### IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:


.....

<p><u>Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:</u></p>	<p><u>Бусад харилцах субъект</u></p> <ul style="list-style-type: none"> <li>- Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, Засаг дарга, Засаг даргын Тамгын газар;</li> <li>- Аймаг, нийслэлийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар;</li> <li>- Аймаг, нийслэлийн Мэргэжлийн хяналтын алба, байгаль орчны хяналтын улсын байцаагч;</li> <li>- Бусад сав газрын захиргаад;</li> <li>- Сав газрын зөвлөлүүд;</li> </ul>
--	---





	<ul style="list-style-type: none"> <li>- Тусгай хамгаалалттай газар нутгийн хамгаалалтын захиргаа;</li> <li>- Усны мэргэжлийн байгууллага;</li> <li>- Байгаль хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн газар, төрийн байгууллага;</li> <li>- Их, дээд сургууль болон эрдэм шинжилгээний байгууллага;</li> <li>- Ус ашиглагч, хэрэглэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага;</li> <li>- Бусад яамд, агентлагууд.</li> </ul>
--	--

**V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ**

<u>Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан:</u>	<u>Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:</u>
<u>Албан тушаал:</u> Усны газрын Удирдлага, санхүүгийн хэлтсийн дарга  О.ГАНТУЛГА 20 <u>20</u> оны <u>10</u> дугаар сарын <u>20</u> ны өдөр	<u>Байгууллагын нэр:</u> ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ <u>Шийдвэрийн огноо:</u> <u>20</u> ..... <u>12</u> <u>23</u> <u>Дугаар:</u> <u>399</u> .....

**Албан тушаалын тодорхойлолт баталсан:**

<u>Байгууллагын нэр:</u> .....ТУУЛ ГОЛЫН..... САВ ГАЗРЫН ЗАХИРГАА <u>Шийдвэрийн огноо:</u> .....2021/01/18.... <u>Дугаар:</u> ....А/01.... ДАРГА 20 <u>21</u> оны <u>01</u> дугаар сарын <u>18</u> ны өдөр	 / Б.ОЮУНБОЛД / 
---	---